

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: СУДАЛГААНЫ ТОЙМ

Б. Хорол-Эрдэнэ

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Үндэслэл ба судлагдсан байдал

Олон улсын түвшинд:

- ГШХО бол эдийн засгийн өсөлтийг дэмждэг (Hanse and Rand, 2006)
- Эдийн засгийн өсөлт болон ГШХО эерэг хамааралтай (Almfraji, Almsafir and Uano, 2014)

Монголд:

- ГШХО эдийн засгийн өсөлтийг шууд болон шууд бусаар дэмждэг (Ананд, 2011)
- ГШХО эдийн засгийн өсөлт болон худалдааны урсгалыг нэмэгдүүлдэг (Мөнхцэцэг & Гантөмөр, 2015)
- ГШХО нь нийгмийн хөгжлийг дэмждэг (технологийн дэвшил, удирдлагын арга барил г.м.)

1. Суурь судалгаа

- Зорилго: ГШХО-ын хэлбэлзлийн гол шалтгааныг тодорхойлох, эдийн засаг дахь нөлөөллийг тооцоолох, улс орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хэрхэн хөрөнгө оруулалтыг татах талаар судлах

2. Нэмэлт 1: Хөрөнгө оруулалтын орчин, худалдааны нөхцөлийн харьцуулсан судалгаа

3. Нэмэлт 2: Харьцуулсан судалгаа

4. Нэмэлт 3: Маргаан шийдвэрлэх, арбитраж

Суурь судалгаа (2017)

ГШХО-д нөлөөлдөг хүчин зүйлс:

- ЭКЗОГЕН хүчин зүйл- Эрдэст бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт
 - Эрдэст бүтээгдэхүүний үнэ болон ГШХО-ын урсгал эерэг хамааралтай
- ЭНДОГЕН хүчин зүйл- Хөрөнгө оруулалтын орчин

Индекс (2016)	Монгол	Чили
Бизнес эрхлэхүй индекс (DBI)	64/190	57/190
Авлигын төсөөллийн индекс (CPI)	87/176	24/176
ХО-ын таатай орчны индекс (IAI)	81/104	39/104
Бодлогын төсөөллийн индекс (PPI)	101/104	35/104
Ашигт малтмалын потенциалын индекс (MPI)	50/104	49/104

- Дүгнэлт

- Монгол Улсад ГШХО-ын урсгалыг удирдах боломж хомс байна.
- Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин ГШХО-ыг татахад хангалтгүй байна.
- ГШХО-ын үр нөлөө нь дотоодын зах зээлд хэр их шингэхээс хамаарна
- Ихэнх ГШХО нь уул уурхайн салбарт хийгддэг бөгөөд шаардлагатай капитал хөрөнгө оруулалтыг дотоодоос нийлүүлэх боломжгүй тул энэ нь ГШХО-ын үр ашгийг бууруулж байна.

Нэмэлт судалгаа 1: Хөрөнгө оруулалтын орчин, худалдааны нөхцөлийн харьцуулсан судалгаа (2018)

- Хөрөнгө оруулалтын орчны үзүүлэлтүүдийг 2017 оны байдлаар шинэчилсэн – Түүхий эдийн өндөр үнэ, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэлэлцээр хөрөнгө оруулалт татах нөхцөлийг сайжруулжээ.
- Монгол болон Чили улсуудын худалдааны нөхцөлийг харьцуулсан.
 - Худалдааны нөхцөл нь тухайн улсын экспорт, импортын үнийн харьцаагаар тодорхойлогддог.
 - Чилийн экспортын 50 орчим хувийг нь эрдэст бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг (1970 онд 84% байсан)
 - Монголын хувьд эрдэст бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 70 орчим хувийг бүрдүүлдэг.
 - Хоёр улсын хоорондох гол ялгаа бол Чили Улс зэсийн хүдэр олборлож, дотооддоо боловсруулан экспортолдог бол Монгол Улсын цэвэршүүлсэн зэсийн экспорт нийт экспортын ердөө 1 орчим хувийг эзэлдэг.
- Дүгнэлт
 - Монголын макро эдийн засгийн зарим үзүүлэлт Чилийнхээс өндөр байгаа боловч институцийн болон хөрөнгө оруулалтын орчин муу хэвээр байна. Энэ нь авлигын түвшин ихтэй, улс төрийн байдал тогтворгүй байдагтай холбоотой.

Нэмэлт судалгаа 2: Харьцуулсан судалгаа (2019)

- Монгол, Казахстан, Перу, Замбитай хийсэн улс орнуудын харьцуулсан судалгаа (уул уурхайн салбар, байршил үндэслэж сонгосон)

Индекс	Монгол	Казахстан	Перу	Замби
DBI (2019)	74	28	68	87
CPI (2018/180)	93	124	105	105
IAI (2017/91)	53	24	19	58
PPI (2017/91)	70	59	43	71
MPI (2017)	65%	78%	78%	63%
Дүнэлт	Геологийн мэдээллийн сан, хөдөлмөрийн нийлүүлэлт, ур чадвар сайжирч, тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой тодорхой бус байдал буурсан.	Эрхзүйн систем сайжирсан, хууль, дүрэм журмын хэрэгжилтийн болон захиргааны тодорхой бус байдал буурсан.	Хөдөлмөрийн нийлүүлэлт, ур чадвар сайжирсан, орон нутгийн хөгжил болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гэрээ, зохицуулалт сайжирсан.	Татварын дэглэм, геологийн мэдээллийн сан болон улс төрийн тогтвортой байдлын талаарх тодорхой бус байдал нэмэгдсэн.

Нэмэлт судалгаа 2: Харьцуулсан судалгаа (2019)

Санал, зөвлөмж:

- Уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлэхэд анхаарах
 - Тэргүүлэх салбар: хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр (мах, ноолуур...)
 - ГШХО татах хамгийн их боломжтой салбаруудаа тодруулах, эрэмбэлэх
- “Нэг цэгийн үйлчилгээ”
 - Зөвхөн уул уурхай гэлтгүй бүх салбарт хөрөнгө оруулах гадаадын бизнес эрхлэгчдэд бичиг баримт бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл авахад нь туслалцаа үзүүлэх
 - Үйлчилгээг цахимаар болон биечлэн авах боломжтой байх
- Тогтвортой орчин
 - Институцийн болон бизнесийн орчин тогтвортой байх буюу хууль журмуудыг ойр ойрхон өөрчилдөггүй байх
 - Урт хугацааны хөрөнгө оруулалтын гэрээнд тогтворжуулалтын заалтууд оруулах
- Ил тод байдал
 - Хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг ил тод болгох (Оюу толгойн гэрээ, зарим уурхайн орон нутагтай байгуулсан гэрээнээс бусад нь хаалттай)
 - Хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрийн явцад орон нутаг, иргэдийн оролцоог хангах

Нэмэлт судалгаа 3: Маргаан шийдвэрлэлт, арбитр (2020)

- Уул уурхайн маргааныг тухайн улсын шүүхийн системээр эсвэл олон улсын арбитрын шүүхээр шийдвэрлэх боломжтой
- Шүүхийн уул уурхайн маргааныг шийдвэрлэх чадвар нь тухайн улсын хууль дээдлэх ёсыг хэр сахин биелүүлж, зохих журмыг хангаж байгаагаас шалтгаалдаг.
- Уул уурхайн салбар дахь харилцааг зохицуулдаг гол механизм нь гэрээ юм. Иймээс тухайн улсын гэрээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах чадвар нь ихээхэн чухал.
- Дэлхийн Банкны "Бизнес эрхлэхүй" тайланд дурдсанаар, гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд 180 орныг дараах үзүүлэлтүүдээр үнэлсэн:
 - Цаг (өдөр)
 - Зардал (нэхэмжлэлийн үнийн дүнгийн %)
 - Шүүхийн үйл ажиллагааны чанарын индекс (QJPI)

Нэмэлт судалгаа 3: Маргаан шийдвэрлэлт, арбитр (2020)

Шүүхийн үйл ажиллагааны чанарын индекс

1. Шүүхийн бүтэц, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
2. Хэрэг шийдвэрлэх менежмент
3. Шүүхийн автоматжуулалт
4. Шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх

Он	Бизнес эрхлэхүй (0-100)		Гэрээний хэрэгжилтийг хангах (0-100)		Цаг (өдөр)		Зардал (нэхэмжлэлийн үнийн дүнгийн %)		Шүүхийн процессын чанарын индекс (0-18)	
	Монгол	Зүүн Ази, Номхон далайн (ЕАР) дундаж	Монгол	ЕАР дундаж	Монгол	ЕАР дундаж	Монгол	ЕАР дундаж	Монгол	ЕАР дундаж
2016	65.3	61.5	58.5	52.7	374	553.8	30.6	48.8	5.5	7.6
2017	66.1	62.0	58.5	52.9	374	560.0	30.6	49.1	5.5	7.9
2018	67.4	62.7	58.5	53.1	374	565.7	30.6	47.3	5.5	7.9
2019	67.7	63.4	61.4	52.8	374	581.1	22.9	47.2	5.5	7.9
2020	67.8	63.3	61.4	53.0	374	581.1	22.9	47.2	5.5	8.1

Нэмэлт судалгаа 3: Маргаан шийдвэрлэлт, арбитр (2020)

- Шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах шаардлагатай.
 - Шүүхийн бүтэц: Арилжааны асуудлаар дагнасан шүүх байгуулах хэрэгтэй (нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай)
 - Хэрэг шийдвэрлэх менежмент: Засгийн газар шүүхийн гүйцэтгэлийн сайн стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх зорилгоор илүү их мэдээлэл цуглуулж, хэрэгжүүлэх хэрэгтэй.
 - Шүүхийн автоматжуулалт: Засгийн газрын хөрөнгө оруулалт, оролцоо шаардлагатай (сайжруулалтад шаардлагатай дэд бүтцийг бий болгох, цахим мэдээллийн сан бүрдүүлэх г.м)
 - Шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх: Одоо байгаа зуучлалын системийн хэрэгжилтийг сайжруулах, зуучлагчдын ур чадвар мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Нэмэлт судалгаа 3: Маргаан шийдвэрлэлт, арбитр (2020)

- Арбитрын тухай хуулийг 2017 онд олон улсын стандартад нийцүүлж шинэчлэн найруулсан.
- Арбитраар маргаан шийдвэрлүүлэх нь хөрөнгө оруулагчдад дотоодын шүүхэд хандалгүйгээр гэрээний хэрэгжилтийг хангах боломжийг олгодог.
 - Оролцогч талууд арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр урьдчилан зөвшилцсөн байхыг шаарддаг онцлогтой (ХОХТГ, ОУХОГ, гэрээ)
- Монгол Улс 42 хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээ (36 хүчин төгөлдөр байгаа) болон 4 олон улсын хөрөнгө оруулалтын гэрээнд нэгдсэн.
 - Иймээс Монгол улсын хувьд арбитраар маргаан шийдвэрлүүлэх талаар нэмэлт заалт гэрээнд тусгах шаардлагагүй.
- Монгол дахь ГШХО, гадаад харилцаа нэмэгдэх тусам хөрөнгө оруулагч болон ЗГ хоорондын маргаан өсөх хандлагатай байна.
 - Энэ нь ЗГ-т зардал ихтэй байдаг учир үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд зохих хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулж, хуульд захирагдах явдлыг сайжруулах хэрэгтэй. (Khan Resources-ийн хэрэг)

Анхаарал хандуулсанд баярлалаа !